



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/03

Гурвансайхан

Бавуудорж овогтой Тэнгэрийг 1 дүгээр багийн
Засаг даргаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4, 56.6 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авлигатай тэмцэх газрын 05/21346 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бавуудоржийн Тэнгэрийг 1 дүгээр багийн Засаг даргаар 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. 1 дүгээр багийн Засаг даргын ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: 3.Золбоо-(ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Оюундарь-(Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүд: Д.Баярмагнай-(Нярав)

Л.Шижирболд-(Нягтлан бодогч)

Б.Баасансүрэн-(Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Багийн Засаг даргад холбогдох баримт бичиг болон эд материалыг журмын дагуу хүлээлгэн өгч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн төрийн албан хаагчийн анкет нээж ажиллахыг комиссын нарийн бичгийн дарга (Б.Оюундарь)-д даалгасугай.

4. Багийн Засаг даргын үндсэн цалинг 1.375.000 (нэг сая гурван зуун далан таван мянган) төгрөгөөр бодож олгохыг ЗДТГ-ын нягтлан бодогч (Л.Шижирболд)-д зөвшөөрсүгэй.

5. Бавуудорж овогтой Тэнгэрийг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Гэрэлт-Од)-д даалгасугай.

ДАРГА



ДОТГОНСҮРЭН

672601013